

"ДОТУУР БАЙРНЫ БАРИЛГЫН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ"-ийн
барилгын тоног төхөөрөмжийн түүвэр

№	Тоноглол, төхөөрөмжийн нэр, марк. шифр	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ/төг/	Нийт үнэ /төг/	
					НӨАТ-гүй	НӨАТ-тай
1	Нөөц усны сав	ш	1	210000	210000	231000
2	Насос	ш	1	380000	380000	418000
3	Септик	ш	1	18000000	18000000	19800000
	ДҮН				18590000	20449000

Септик гэж юу вэ?

Септик нь ахуйн бохир усыг тунгааж, тунгаасан лаг үлдэцээ хадгалан боловсруулж халдваргүйжүүлэх зориулалттай байгууламж юм.

Септик системийн ажиллах зарчим.

Септикт бохир ус орж 2-3 хоног тунгаагдах ба тунасан лаг үлдэц нь байгууламжийн ёроолд 6-12 сар анаэроб /агааргүй орчны/ бичил биетийн тусламжтайгаар боловсрогдон хий үүсгэх ба зарим хэсэг нь ууссан эрдсийн нэгдэл болон хувирна.

Септик танк нь цэвэрлэх байгууламжийн нэг хэсэг бөгөөд түүнийг дангаар нь ашиглахгүй.

Септикийн ус цэвэрлэгээний үр дүнг органик бохирдлын үзүүлэлтээр /БХХ/ 25%, умбуур бодисоор 75% хүртэл байна гэж үздэг. Иймээс септикийн дараа биологийн цэвэрлэгээ хийх ба дараагийн шатны цэвэрлэгээний байгууламж нь газар доорх шүүрүүлэх талбай, шүүрүүлэх худаг, ашиглах нь хамгийн тохиромжтой байдаг. Хөрсөөр шүүрүүлэх цэвэрлэгээ нь байгалийн аргаар явагдах бөгөөд шүүгдэж цэвэрлэгдсэн ус хөрсний усанд нэвчин орно. Бохир ус хөрсөөр шүүгдэх явцад түүнд умуур болон коллойд бодисууд шүүгдэн үлдэж энэ хэсэгт бичил биетээс бүрдсэн биологийн хальс үүсдэг. Бичил биетүүд нь органик бохирдлыг исэлдүүлэн эрдсийн нэгдэл болгодог. Хөрсөөр шүүгдэж цэвэрлэгдсэн бохир усны биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 15мг/л, тогтворжилт нь 99% байна.

Септик систем дээр 30-50см шороо овоолж өгөх ёстой ба шороо нь 1-2 жилдээ хөрсөнд сууж тэгширдэг юм. ~~Тусгай дээр Вехиетэйг хэсэгтэй шороо овоолгоо~~ үүнээс гарах эрдсэл болон газрын суулт үүсэж нүх гарсан тохиолдолд Гүйцэтгэгч тал хариуцахгүй.

Септикийн ашиглалт

Септикийг ашиглалтанд оруулахдаа түүнд шууд бохир усаа хийж эхэлнэ. Септикийн ажиллагааг эрчимжүүлэхийн тулд түүнтэй ижил төстэй ажиллаж буй байгууламжийн боловсрогдсон лаг үлдэцээс /исгэх хөрөнгө/ зөөвөрлөн авч ирэн септик камерын эзлэхүүний 15-30% тай тэнцэх хэмжээгээр хийж болно.

Септикийн ашиглалтыг эрчимтэй эхлүүлэх зорилгоор төрөл бүрийн бэлэн бэлдмэлүүдийг /бичил биетүүд/ худалдаалдаг боловч, тэдгээрийн зарим нь септикийн нөхцөл дасан зохицож амьдрах чадваргүй, нүхэн жорлонд зориулагдсан нэг удаагийн хэрэглээний зэрэг төрөл бүрийн зориулалтын байдаг тул сонголтоо зөв хийх шаардлагатай. Орчин үед хэрэглэж буй био бэлдмэлүүд нь лагийн исэлдүүлэлтийн процессын хурдыг түргэсгэхээс гадна септик болон шугам хоолойн ашиглалтын хугацааг уртасгадаг. Эдгээр бэлдмэлүүд нь хүн ба амьтанд, хүрээлэн буй орчинд бүхэлд нь аюулгүй гэж үздэг.

Эдгээр био бэлдмэлүүд буюу бактерүүд нь шингэн ба хуурай төлөв байдалд байж болно. Тэжээлийн орчиндоо оронгуут, тухайлбал септикт бичил биетүүд органик бохирдлыг боловсруулж орчиндоо дулааныг болон эрдэс бодисыг ялгаруулдаг. Усанд ууссан эрдэс бодис нь хөрсөнд шингэж, уусаагүй нь септикийн ёроолд тунаж үлдэнэ. Боловсруулалтын үр дүнд лаг үлдэцийн эзэлхүүн анхны хэмжээнээсээ 15-20 дахин багасдаг. Септик нь бохир усанд амьдрах бактериар-л ажилладаг. Иймээс ашиглалтын хэвийн горимыг богино хугацаанд бий болгоё гэвэл дээр заасан зааврыг мөрдөх хэрэгтэй.

Анхаарах зүйлс:

- Септикийг ашиглалтанд оруулаад ойролцоогоор 1-2 сар болсоны дараа л түүнээс анхны лаг үлдэцийг зайлуулахад болно. Лаг зайлуулах болсон байна уу гэдгийг түүний түвшинөөр тодорхойлж болно. Лагийн гүнийг хэмжих хэрэгслийг септикт дүрж гарган түүн дээр наалдаж үлдсэн лагийн хэмжээгээр түүнийг тэмдэглэн авж лагын түвшин септикийн бохир ус гадагшлуулах халилтын хоолойн түвшин хооронд 1 метрт ойртсон үед соруулж зайлуулна.
- Септикт ногооны хаягдал, 00-н цаас, элс шохой зэрэг нунтаг материал мөн биологийн аргаар задардаггүй бодис /полимерүүд/ хийж болохгүй, септикийн бактерүүд нь ийм

хаягдлаар хооллохгүй, харин эдгээр нь илүүдэл хаягдал үлдэцийг бий болгож сисемийг бөглөрч таглархад хүргэнэ.

- Эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд зөвхөн гүйцэтгэгч компанируу холбоо барих.
- Септик танк байрлуулсан газар дээгүүр машин явуулж болохгүй.
- Бохир усны лагыг соруулж зайлуулсны дараа септик савны дулаалагыг нь хийж агаар орхооргүй болгож сайтар тагла.